**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 05 сарын 04 өдөр Дугаар А/176. Мандалговь

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын гэр хороололд 2008 оны 05 дугаар сарын 01-нээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 2 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 127 дахь хэсэг, 2008 оны 77 дугаар захирамжийн хавсралтын 12 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Хамтран өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

4812104?7

*Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А/176 дугаар захирамжийн хавсралт*

| № | Газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэн | | | | Газар өмчлөх эрх шилжүүлсэн | | Газрын байршил | Газрын хэмжээ /м2/ | Газрын үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Нэр | Регистр | Овог нэр | Регистр | | | |
| 1 | Бэгз | Дулам | Цэнгэлмаа | ЗД74072901 | Б.Бямбацогт | ЗМ75041216 | Мандал 2-220 | 639 | 1278000 |
| | | | | | Б.Балжинням | ЗМ01222510 | | | |
| | | | | | Б.Мөнхсайхан | ЗЛ96122901 | | | |
| | | | | | Б.Мөнхдэлгэр | ЗМ05230302 | | | |
| 2 | Зуут | Шагдаржав | Намсрайжав | ЗЮ93070417 | Г.Даариймаа | ЗЮ57042001 | Боржигон 15-1513 | 1915 | 3830000 |